

УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИЙН ҮҮРЭГ¹****Д.БОЛД-ЭРДЭНЭ***ШУА-ын Философийн хүрээлэн. Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор*

Түлхүүр үг: философи, үүрэг, эргэлзээ, шүүмжлэлт сэтгэлгээ, оюуны соёл

* * *

Философийн үүрэг хэмээх асуудалд бид ихээхэн албархаг хариулт өгөхийг оролддог. Үүнийгээ философийн *танин мэдэхүйн* болон *арга зүй, ертөнцийг үзэх үзлийн үүрэг* гэгчтэй холбон ерөнхийлсөн, хэлбэрдсэн тайлбар өгсөөр ирсэн байдаг. Гэтэл угтаа философийн үүргийн тухай асуудал бол эцсийн дүндээ хүн, философийн харилцан хамаарлын тухай асуудал юм. Тодруулбал энэ нь хүн философиор оролдсоноор хүнд философи юу өгөв, хүн философиос юу авав, философи хүнийг өөрчлөхөд ямар нөлөө үзүүлдэг вэ? гэдэг тухай асуудал юм. Товчоор хэлбэл энэ нь философийн хүнд өгөх *ашиг тусын тухай л асуудал* юм. Философийн чиг үүрэгт хамаарах энэ чанар улс төрийн философид ч мөн бүрэн хамаарна. Тийм болохоор улс төрийн философийн хүнд өгөх ашиг тусын тухай асуудал нь угтаа философид ч мөн нэг адил хамааралтай юм.²

Философид хүмүүс янз бүрээр ханддаг. Хүмүүсийн нэг хэсэг нь түүнийг үл ойшоодог бол нөгөө хэсэг түүнийг хүндэтгэвэл зохих мэдлэгийн салбар тул хүн бүхэн бүрэн эзэмшдэггүй юм гэхэд зах зухаас нь гадарладаг байх ёстой хэмээдэг. Тэгвэл үлдсэн хэсэг нь философи бол хүний амьдралын салшгүй хэсэг тул түүнийг хүмүүс эзэмшиж, философидож сурах хэрэгтэй гэгчдэдэг. Бертран Рассел “Философи сэтгэлгээ суугаагүй хүмүүс бүүр эрт дээр үеэс философид ерөнхийд нь сониуч бөгөөд зөрчилтэй хандаж иржээ. Нэг талаас, хүмүүс философичдыг үүл манан дотор умбаж, хүний бодит амьдралд хамааралгүй мулгуу асуулт тавьж явдаг гэм хоргүй тэнэг, жирийн сайхан иргэдийн сэтгэлийг хөндөж буй асуултуудад хайхрамжгүй ханддаг гажигтнууд хэмээн үзэж өршөөнгүй хандаж байхад нөгөө талаас философи нь тогтсон төлөв, ёс заншлыг үндсээр нь нураах нөлөө үзүүлэх чадалтай зүйл байв. Ийм нөхцөлд философичдыг ёс заншлыг уландаа гишгэн уламжлалыг хөсөрдүүлэгч, бусад нь хүлээн авч болоод байгаа үзэл бодол, дадал заншлуудыг хүлээн зөвшөөрдөггүй сөрөг бодолтой хэмээн сэжиглэнгүй ханддаг байв”³ гэсэн байдаг.

Философийг сэтгэгчид *онолын* болон *амьдралын* гэсэн хоёр үндсэн агуулгаар тайлбарлахыг оролддог. Ингэхдээ энэ хоёрын аль нь жинхэнэ философи вэ гэх зэрэг асуултыг тавих нь байдаг. Оросын нэрт философич Б.С. Соловьев бичихдээ: “Хэдийгээр “философи” гэсэн үг онож тодорхойлсон нэг утгатай бус боловч өөр хоорондоо үлэмж ялгаатай олон утгаар хэрэглэгддэг буй. Бид философийн тухай хоёр гол, бие биеэс ялгаатай ойлголтуудтай юуны өмнө учирдаг, үүний нэг дэхээр бол философи нь зөвхөн онол, зөвхөн сургуулийн хэрэг, хоёр дахиаар бол тэр нь онолоос ч илүү, голчлон амьдралын хэрэг... Нэг дэх ойлголтоор бол философи нь хүний дан ганц танин мэдэх чадварт холбогдоно, хоёр дахиаар бол тэр нь хүний зориг хүслийн эрхэм эрмэлзлэлд хүний мэдрэмжийн эрхэмнэлд тохирдог, ингэхлээр, зөвхөн онолын төдийгүй, мөн зан суртахууны болон гоо сайхны утга холбогдолтой. Нэг дэх философи нь дан ганц онолын асуудал эрхлэх тул хувийн болон нийгмийн амьдралтай шууд дотоод холбоотой бус, хоёр дахь философи нь энэ амьдралыг үүсгэгч, жолоодогч хүчин байхыг эрмэлзэнэ”⁴ гэсэн байдаг. Эндээс үзвэл философийг хэдэн хийсвэр ойлголт, томъёолол, хууль, зарчмын хоосон цуглуулга гэж ойлгож болохгүй. Харин энэ нь уг чанараараа онолоос ч илүү гарах, амьдралын бодит үндэстэй холбогдох гүн гүнзгий утга агуулгатай бөгөөд философийн суурь

¹ Эл өгүүлэл нь зохиогчийн “Улс төрийн философи: тулгуур асуудал” II боть бүтээлийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн хувийн эргэцүүлэл, тэмдэглэл болно. Бүтээлд цаашдаа эл асуудлыг нарийвчлан авч үзэх болно.

² Философийн хүнд өгөх ашиг тусын тухай асуудал нь улс төрийн философид ч мөн нэг адил хамаатай гэж үзээд энэ удаа түүний чиг үүргийг ерөнхий философийн үүрэгтэй адилтган тэдгээрийг нэг агуулгаар авч үзэж тайлбарласан болно. Үүний учир гэвэл улс төрийн философи нь угтаа философи мэдлэг болж байдагт оршиж байна.

³ Бертран Рассел. Өрнийн мэргэн ухаан. 78 дахь тал

⁴ Б.С. Соловьев. “Исторические дела философии”. Вопросы философии. 1988. №8.

зарчмууд нь хүний амьдралын бодит хөрсөн дээр бугаад ирэхлээр амьдралыг философидон ойлгох, ухааран эрэгцүүлэх гайхамшигтай удвасыг хүнд өгдөг байна. Тиймээс ч Б.С. Соловьев философийн онолын болон амьдралын талын аль нь үнэнхүү философи вэ? гэсэн асуудлыг өөртөө тавиад "...тэдгээрийн нэгийн хувьд энэ үг зөвхөн хийсвэр онолын утга холбогдолтой бол нөгөөгийн хувьд амьд, жинхэнэ утгатай"⁵ гэсэн байдаг.

Философи бол сурч чадах зүйл биш, харин философийн үүднээс бодож чадах тийм зүйл юм гэж ярилцдаг. Тэгэхлээр философид "суралцана" гэдэг нь аливаад философи талаас нь хандаж, бодож эрэгцүүлэх арга ухаан, чадварыг эзэмшихэд суралцана гэсэн үг. Философийн асуултууд хийсвэр ерөнхий байдаг тул түүнийг зарим хүмүүс хоосон номчирхсон, амьдралаас тасархай зүйл гэх нь байдаг. Гэтэл угтаа философи бол тийм биш, харин ч энэ нь хүний амьдралын салшгүй хэсэг төдийгүй түүний янз бүрийн тал, үзэгдлийн цаана буй ерөнхий зарчим, бодит шалтгаал, түүний утга учрыг ойлгон баримжаалахад тусалдаг оюун санааны түшиг тулгуур, түүний идэвхт үйл юм. Философи хэмээх танин мэдэхүйн энэ онцгой хэлбэрийн агуулга нь Байгалийн болон Хүний ертөнцийн үзэгдэл, үйл явцыг шалтгаант хэлхээ холбоонд нь цаад уг чанараас нь эх аван судлаж дүгнэлт мэдлэг гаргадагт оршино.⁶

Философи бол хүнтэй холбогдох агуулгаараа бүхэлдээ амьдралын философи мөн. Эртний Грекийн сонгодог философич, сэтгэгч Сократ учрыг нь мэдэж чадаагүй амьдралыг туулах нь утга учиргүй зүйл хэмээсэн байдаг. Тэгвэл хүнд амьдралынхаа утга учрыг ойлгон баримжаалахад философи тусалдаг. Хүн амьдралаа хэрхэн ойлгох ёстой вэ, түүнд хэрхэн хандах учиртай вэ, амьдралын их далайд хүн чиг баримжаагаа алдчихгүй хэрхэн өөрийгөө авч явах вэ? гэсэн хүний амьдралын мөнхийн асуултад философи хариу өгөхөд хэрэгтэй байж болох боломжуудыг хүмүүст өгч байдаг. Энэ чанараараа философи нь хүмүүсийг амьдралын цаад бодит үндсийг нь барьж сэтгэх бүтээлч үйлд өдөөдөг оюунлаг өдөөгч юм. Хүн философийг эзэмшинэ гэдэг нь философидох арга барилыг эзэмшинэ гэсэн үг. Философидоно гэдэг бол философи өөрийгөө ойлгох, хүн өөрийгөө танин мэдэх, ингэснээрээ амьдралын улам илүү сайн зарчмыг олж эзэмших эцэс төгсгөлгүй эрэл, бүтээлч сэтгэлгээнд суралцах гэсэн үг юм. Философдоно гэдэг нь ухаалаг амьдрахын утга учрыг эрж олно, түүнийг тайлна гэсэн үг.⁷

Философидох гэдэг нь энгийн агуулгаараа хүн *философийг хэрэглэх* явдал юм. Тиймээс ч философийн хүнтэй холбогдох гол илэрхийлэл нь хүний оюун ухаан, сэтгэлгээнд *философийг хэрэглэх* явдал байдаг. Тэгэхдээ энэ нь механик зүйл биш, маш нарийн чимхлүүр бодит үндэстэй зүйл юм. Энэ тухай философич Б.Даш-Ёндон "Философийг хэрэглэх гэдэг нь танин мэдэхүйн асуудалд холбогдох сэтгэлгээний үзэгдэл юм. Танин мэдэхүйд философи сэтгэлгээг ашиглах нь чухал. Тодорхой асуудлыг философийн үүднээс авч үзэх гэдэг санаа философийн ертөнцөд тарчихсан зүйл; улмаар аливаа шинжлэх ухааны хийсвэрлэл шаарддаг мөчлөгүүд дээр ч энэ санаа чухал ач холбогдолтой юм. Судлаач, уран бүтээлч хүн философи сэтгэлгээний соёлтой болж чадсан цагтаа л амжилт сайтайгаар бүтээн туурвидаг байна"⁸ гэж бичсэн нь анхаарал татаж байна. Ингэхлээр философийг хэрэглэх гэдэг нь хүн аливаа асуудалд үндэстэй эргэлзэж, буйртай эрэгцүүлэн сэтгэж, философийг сэтгэх арга барилынхаа үндэс болгож, түүнийг сэтгэх урлаг, ур чадварын түвшинд ашиглана гэсэн үг юм.

Философи амьдралын гүнээс үүсвэрлэж, түүнээс эх ундрага авч, хөгжиж байдаг бүтээлч зүйл юм. Философи өөрөө бүтээлч байхын зэрэгцээ бас түүнийг эзэмшигч, философидогч субъектыг мөн бүтээлч байхыг шаарддаг. Ингэхлээр философийг эзэмшинэ, философидох арга барилд суралцана гэдэг нь хэнд дуртай нь хэрэгжүүлчих амар хялбар ажил бас биш. Үүний нэг адил хүн улс төрийн философиор оролдож, улс төрийг философидож сурах нь амаргүй зүйл юм. Философид суралцаж болох боловч ер нь ихэнхдээ олж авсан мэдлэгээ оюун сэтгэхүйн эрэгцүүлэлд ашиглаж, хэрэглэж чаддаг хүмүүс философидог нь санамсаргүй хэрэг биш юм. Энд зайлшгүй хэрэгжүүлэх ёстой хэм хэмжээ, баримтлах ёстой шаардлага шалгуур гэж байдаг.

Кант философийг эзэмших, философидох арга барилд суралцахад шаардагдах шалгуур шаардлагын тухай тодорхой өгүүлсэн байдаг. Тэрээр бичихдээ: "философичид гол төлөв: 1. Боллоцоог бүх зорилтод хэрэглэхийн тулд авьяас болоод чадварын соёл, 2. Аль аль хэрэгслийг ямар нэг зорилгоор хэрэглэх дадлага гэсэн хоёр юм шаардагддаг байна. Мэдлэггүйгээр хэзээ ч философич болохгүй учраас энэ хоёр ч нэгдэх ёстой мөн оюуны бүх мэдлэг дадлага хоёрын зорилгод нийцсэн холбоо нэгдлийг төрүүлэхгүй бол, энэ нэгдлийг хүний ухааны дээд зорилтод нийцүүлэх ухамсар төрөхгүй бол дан ганц мэдлэгээр философич болдоггүй. Ер нь философидож чаддаггүй хүнийг философич гэж нэрлэж болохгүй. Гагцхүү дасгал сургууль хийж ухаанаа бие даан хэрэглэсний үрээр л философидож сурна. [... Тэгвэл философидож сурахыг хүсэж буй хүн философийн бүх тогтолцоог гагцхүү оюун ухааныг хэрэглэсний түүх, бас философийн авьяас билгээ дасгалжуулах объект гэж үзэх ёстой. Ийм учраас жинхэнэ философич бие даасан сэтгэгчийн хувьд оюун

⁵ Мөн тэнд

⁶ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи \ асуудал, аргачлал, ашиг тус\ 85-86 дахь тал.

⁷ Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохуй. 8 дахь тал.

⁸ Б.Даш-Ёндон. Дурьдсан бүтээл. 87 дахь тал.

ухаанаа боолын ёсоор дуурнах биш чөлөөтэй бөгөөд өвөрмөц содон хэрэглэх ёстой”⁹ гэсэн байдаг.

Философийн хүнд өгдөг *ашиг тус* нь юу вэ? хэмээх нь бидний сонирхож буй гол асуулт юм. Энэ асуултанд философи нь хүнийг өөрийгөө таних, амьдралын бодит утга учрыг ухааран ойлгоход тусалдаг гэж хариулах нь үнэндээ ерөнхий хариулт болдог. Харин энэ ерөнхий нотолгоог тодорхой үндэслэх хэрэгтэй. Энэ үүднээс асуудалд хандаж үзвэл улс төрийн философи ашиг тусын талаар зарим зүйлийг тодруулж болох байна.

Философи бол эргэлзэх арга болдог. Францын философич Пьер Абеляр “Эргэлзээ бол танин мэдэхүйн үндэс” гэсэн нь санамсаргүй хэлчихсэн зүйл биш юм. Эргэлзээ нь хүнийг философид өдөөдөг бол философи нь бас эргэлзээг өдөөдөг байна. Аристотель бичихдээ: “... одоо ч, өмнө нь ч хачирхал хүмүүсийг философидох ажил руу өдөөжээ. Тэхдээ эхний үед хүмүүс шууд гайхалыг нь төрүүлдэг тэр зүйлд хачирхдаг байв, дараа нь ийм маягаар цаашаа аажим аажмаар ахисаар илүү их учир холбогдолтой том зүйлийн тухай, ... асуултыг бодож үзэх болсон байна. Тэгээд эргэлзэж, гайхаж байгаа хүн өөрийгөө юм мэдэхгүй байна гэж үздэг байлаа. ... Ингэхлээр, хэрэв үл мэдэхүйгээс ангижрахын тулд философидож эхэлсэн юм бол ямар нэг ашиг хонжооны төлөөнөө бус, харин ойлгохуйн төлөөнөө мэдлэг рүү эрмэлзсэнээс болжээ гэдэг нь тодорхой байна”¹⁰ гэсэн байдаг. Эндээс үзвэл философи хүнийг эргэлзээнээс ангижруулж, мэдлэг рүү хөтөлдөг байна. Тэгэхлээр энэ чанараараа философи нь хүнд зүйрлэшгүй ашиг тустай байдаг.

Хүн философийг хэрэглэж, түүнийг сэтгэх үйл ажиллагааныхаа үндэс болгох үйл явц нь эхлээд хүний аливаад *эргэлзэх эргэлзээнээс* эхэлдэг. Эргэлзээ бол сэтгэлгээний маш сайн зүйл, энэ нь бас мэдлэгт суурилдаг. Философич Р.Декарт тогтолцоот эргэлзээний арга хэмээх одоог хүртэл үр ашигтай хэрэглэгдэж буй аргыг боловсруулжээ. Тэрээр маш тодорхой бөгөөд маргаангүй үнэн хэмээн тооцож буй зүйлээс бусдад юу ч байлаа гэсэн итгэж чадахгүй хэмээн үзэж байв. Эргэлзэж болох бүхий л зүйлсэд тэрээр эргэлзэх шалтгаан байхгүй болтол эргэлзэх ёстой хэмээн үзэж байв. Энэхүү аргыг хэрэглэх замаар тэр бүрэн итгэлтэй байж болох ганц зүйл нь өөрөө өөрөө оршин байгаа явдал мөн гэсэн дүгнэлтэнд аажмаар хүрсэн байна.¹¹ Ингэж Р.Декарт өөрөө оршиж байгаагаас бусад зүйлст философидож байгаа хэн ч бай ямагт эргэлзэж байх ёстой хэмээгээд эргэлзээг сэтгэлгээний хэвийн эрүүл үзэгдэл гэж үзсэн байдаг. Аливаад хүн эргэлзэх ёстой. Ингэхгүйгээр бүх юмыг сохроор дагана гэдэг нь утга учиргүй бас ухаангүй хэрэг юм. Аливаад эргэлзэх сэтгэлгээ нь хүний итгэлгүйн шинж биш, харин асуудалд буйртай, бодитой ухаалаг хандахын суурь болдог. Хүн эргэлзэх, гайхах юман дээр гайхаж эргэлзэж байх ёстой. Эргэлзээ бол ухаархын эхлэл юм. Эргэлзээг тайлахад философи хүнд тусалдаг.

Философи нь эрэгцүүлэн бясалгах чадвар болдог. Хүний амьдрал бүхэлдээ эрэгцүүлэл түүнээс үүдсэн бясалгал байдаг. Эрэгцүүлэл бясалгалгүйгээр амьдрал утга учиргүй юм. Тэгэхлээр хүн мэдэхгүйгээр амьдралыг туулах нь утгагүй хэрэг гэж Сократ санамсаргүй хэлээгүй байх нь. Харин хүн өөрийгөө таних, амьдралыг мэдэх хэлбэр нь философи, философидолт юм. Ингэхлээр философи, философидолт бол гүнзгий эрэгцүүлэл, бясалгал мөн. Харин эрэгцүүлэл, бясалгал бол үнэнийг эрэлхийлэл оюунлаг чадвар мөн. Лео Штраус философийн мөн чанар бол үнэнийг эзэмших биш, харин түүнийг эрж хайх явдал юм гэсэн байдаг.¹² Үнэнийг эрж хайх гэдэг нь оюуны тасралтгүй бүтээлч үйл ажиллагаа мөн бөгөөд энэ нь эргэлзэхээс эхлээд эрэгцүүлэн бясалгах бүхэл үйл явц байдаг. Хүн эхлээд эргэлзэнэ дараа нь *эрэгцүүлнэ*. Эрэгцүүлэн бодсоны үрээр эргэлзээг ямар нэг байдлаар тайлах эсвэл бүр цаашаа дахин эргэлзэж, улам гүнзгий эрэгцүүлэн бясалгахад хүрдэг. Энэ чанараараа философи бол эргэлзээ төдийгүй бас бүхэлдээ эрэгцүүлэл түүний чадвар болдог байна. Үүнтэй холбогдуулан Бэртран Рассел “Эрэгцүүлэн бодох үйл ажиллагаа бол мөн л танин мэдэхүйн нэг төрөл бөгөөд энэ бол юуны өмнө философи болой”¹³ гэж бичсэн байдаг нь тохиолдлын хэрэг биш. Хүн аливааг эрэгцүүлэн бодох болсон тэр үеэс философидож эхэлдэг гэж Гегель бас хэлсэн байдаг. Философидолтоос бясалгал үүддэг. Тийм болохоор хүний эргэлзээнд суурилсан эрэгцүүлэл нь угтаа түүний гүнзгий бясалгал буюу философидолтын суурь болдог.

Эрэгцүүлэл нь алхам тутамдаа философид тодруулбал философийн ерөнхий зарчим, ойлголт, хэм хэмжээнд суурилж байдаг. Хүний философи эрэгцүүлэл нь зарим тохиолдолд угтаа гайхамшигт шинжийг өөртөө агуулдаг. Энэ чанараараа философи нь хүний аливааг эрэгцүүлэх арга, эв дүй, ур чадвар, зарим тохиолдолд бүр урлаг, яруу найрагтай ч эн тэнцүү сэтгэлгээний онцгой хэлбэр болж чаддаг. Учир нь философи бясалгал нь хүнийг сэтгэн бодох, эрэгцүүлэхийн цэнгэл эдлүүлдэг чанараараа урлаг бас яруу найрагтай ч дүйж очих гайхамшигт чадвар юм. Оросын нэрт философич Н.Я.Грот философийг яруу найраг бас урлаг гэж үзсэн байдаг. Тэрээр философи яруу найраг, урлаг болохын үндэс нь *мэдрэмж* юм гэсэн байдаг. Тэрээр бичихдээ: “Мэдрэмж бол философич яруу найрагч хоёрыг бүхнээс ойртуулж, аль алиных нь бүтээх эхний сэдэл, эцсийн зорилт нь болдог зүйл юм.... Шинжлэх ухаанууд бол задлан шинжилгээ мөн, тэдгээрийн үндэс

⁹ И.Кант. Трактаты и письма. М., 1980. С.333

¹⁰ Аристотель. Метафизик. (Б. Даш-Ёндон. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. 32 дахь тал)

¹¹ Бэртран Рассел. Философийн асуудлууд. 15 дахь тал.

¹² Лео Штраус. Введение в политическую философию. С 10.

¹³ Бэртран Рассел. Өрнийн мэргэн ухаан. 13 дахь талд үзнэ үү.

нь эзэмших явдал, хэрэглүүр нь ажиглалт юм. Урлаг бол синтез мөн, түүний үндэс нь уран бүтээл, хэрэглүүр нь дүрслэн бодохуй юм...Өнөөг хүртэл синтез бол мөн адил шинжлэх ухааны хэрэг гэж бодож байсан нь буруу юм. Шинжлэх ухаан бол объектив мэдлэг мөн, харин синтез бол нэгэнт мэдлэг биш бөгөөд зөвхөн мэдлэгийн эцсийн үр дүн бүтээгдэхүүн нь бөгөөд тэр нь урлаг юм. Шинжлэх ухаан дахь синтез бол анализаа өргөтгөх хийгээд шалгахад тусалдаг туслах хэрэгсэл юм. Синтез заавал ямар нэг практикийн суурьтай байдаг бол анализ нь ямагт онолын хөрстэй байдаг. Синтезийн практик суурийн эцсийн сэдэл нь ямар нэг мэдрэмж гарцаагүй болж байдаг бөгөөд үүнд л урлагийн ялгарах шинж оршиж байна. Урлаг шинжлэх ухаан хоёрын харилцааг яв цав тодотгосноор философи бол синтез, субъектив зүйлийн тусгал, уран бүтээлийн үр дүн болохын хувьд шинжлэх ухаан бус харин урлаг юм гэсэн дүгнэлтэнд төвөггүй хүрнэ. Ингэж нэр солих нь үгийн тухай энгийн маргаан төдийгөөр зогсохгүй, тэр нь философийг үзэх үзэлд язгуур эргэлт гаргах чадвартай юм”¹⁴ гэсэн байна. Тэрээр цааш нь философи яруу найрагтай адил болохыг тэмдэглэж бичихдээ: “Яруу найргын бүтээлүүд философийн бүтээлтэй нэг адил зөвхөн тодорхой эрин үед тодорхой хүмүүсийн таашаалыг хангаж бусдын нь таашаалыг хангадаггүй бол шинжлэх ухаанд таашаалын тухай ярих нь инээдэмтэй байхсан билээ. Эндээс хөгжим болон уран зургийн янз бүрийн сургуулиуд юмуу яруу найргын ба яруу үгийн бүтээлд тодорхой дүрс хийгээд чиглэлүүд давамгайлдаг шиг философийн янз бүрийн системийн ноёрхолд тодорхой орчил болоод уламжлал байдаг нь харагдана. Тэр ч байтугай уран зураг, хөгжим, яруу найраг ба философийн бүтээлүүдэд хандах таашаал олон янз, хувьсамтгай ч гэсэн тэр бүгд үнэхээр сайн бүтээл бол бид бүгд тэдгээрийн ерөнхий санааг хуваалцахгүй, зарим гүйцэтгэлийг нь сайшаахгүй байлаа ч гэсэн бидэнд дандаа агуу их, эрхэм дээд юмны сэтгэгдэл төрүүлж, гоо сайхан болон яруу зохишлын мэдрэмж төрүүлж, догдлуулах адил хэмжээний чадвартай. Платон, Аристотель, Декарт, Спиноза, Кант нар өөрсдийн бүтээлүүдээрээ хүн болгонд Фидий, Софокл, Еврипид, Рафаэль, Моцарт, Шекспиртэй адил хүмүүсийн гайшрал, хүндэтгэлийг төрүүлж байна”¹⁵ гэж бичсэн байна. Ингэхлээр философи бол эрэгцүүлэн бясалгах гайхамшигт цэнгэлийг хүнд өгч чадах, сэтгэлийн асар их татах хүч, увидас бүхий оюунлаг мэдлэг юм.

Философи нь хүний өөрийгөө хянах арга болдог. Хүний өөрийгөө хянах чадвар бол өөрийгөө танин мэдэх арга мөн гэж Сократ нэгэнтээ хэлсэн байдаг. Агуу Платон ч гэсэн хүн сэтгэлийн гүн дэх муу зуршилаа барьж, хянах чадвар бол хүний оюуны гахамшигтай чанар хэмээн бичсэн байдаг. Хүн өөрийгөө хянах гэдэг нь хүн өөртөө оюун санааны хувьд хяналт тавьж, оюун ухаан өөрөө өөрийгөө авч үзээд хариу үйлдэл үзүүлж буй хэрэг юм. Үүнийг философид *рефлекс сэтгэлгээ* хэмээдэг. Рефлекс нь хариу үйлдэл үзүүлэх сэтгэхүйн хэлбэр юм.

Философи мэдлэгийн уг чанар ийм сэтгэлгээг хөгжүүлж байдаг. Өөрөөр хэлбэл, мэдлэг өөрөө өөрийгөө хянах байдлыг философи шинжтэй хэмээнэ. Энэ агуулгаараа философи нь рефлекс мөн.¹⁶ Хүн өөрийгөө хянах гэдэг нь түүний оюуны рефлексийн тодорхой илэрхийлэл байдаг. Нэг ёсондоо хүн өөрийгөө хянах рефлекс сэтгэлгээтэй байна гэдэг нь хүн эмх цэгцтэй, зөрчилгүй, зөв нямбай сэтгэж сурна гэсэн үг юм. Хүн зөв нямбай цэгцтэй сэтгэж чадахгүй бол тэр хүн сэтгэх явцдаа өөрийгөө хянаж чадахгүй байна гэсэн үг юм. Харин философи боловсролтой, соёлтой хүн бол өөрийнхөө сэтгэх хэв шинж, үйл хөдлөлд бодитой хяналт тавьж чаддаг. Философи нь хүний бодол сэтгэлгээ, ойлголт, хэлний утга чанарыг тодотгож, ойгомжтой цэгцтэй болгох үүргийг гүйцэтгэдэг.

Тэгвэл зөв нямбай сэтгэх гэдэг нь юу гэсэн үг вэ? гэсэн асуулт эндээс зүй ёсоор гарч ирнэ. Энэ нь хүн аливааг эрэгцүүлж, бясалгаж хандахдаа юуны түрүүнд *дэс дараатай сэтгэх явдал* юм. Сэтгэх явцад дэс дараалал маш чухал байдаг. Энд тэндээс нь эмх цэгцгүй, алдаг оног, барьц муутай сэтгэх нь өөрийгөө бусдал илэрхийлж чадахгүйгээр барахгүй бусдаар үнэлүүлж чадахгүйд хүрдэг. Харин философи нь хүний бодол санааг тодотгож, цэгцтэй болгож тэр хэрээр шийдвэрээ нарийн, нягт нямбай шалгуураар гаргаж, өөрийгөө сайн илэрхийлэхэд сургадаг.

Сэтгэх үйл явцын дараалал нь бүхэл цогц уялдаатай олон үе шат, дамжлага бүхий нарийн үйл явц мөн. Сэтгэх үйл явцын ерөнхий дэс дараалал нь эхлээд тухайн үзэгдэл, үйл явцын тухайд хүртэж, мэдэрч тэдгээртэй танилцахаас эхлэнэ. Энэ нь уг үйл явцыг харж мэдэрч, уг үзэгдлийг бүхэлд нь сэтгэлдээ багтааж баримжаалж буй хэрэг юм. Дараа нь уг үзэгдэл, үйл явцын дотоод шалтгаант хамаарлыг тодорхойлох хэрэгтэй болно. Үзэгдлийн шалтгаант хамаарлыг тодруулна гэдэг нь угтаа тухайн үзэгдэлд нөлөөлсөн олон хүчин зүйлийг өөр хооронд нь нягт уялдаа хамааралтай цогц байдлаар харьцуулан авч үзэх явцдаа тэдгээрийг эрэмблэн ялгаж, чухал ба чухал бус, үндсэн ба үндсэн бус, гол ба гол бусаар нь зааглан тэдгээрийн нөлөөллийн шинж байдлыг ялгавартайгаар үнэлэн цэгнэнэ гэсэн үг.

Үзэгдлийн шалтгаант хамаарал, хүчин зүйлийн асуудлыг тодруулан мэдсэнний дараа түүнээс шууд үүдэн бий болдог тухайн үзэгдэл, үйл явцын шинж байдал, онцлог, өрнөл хэмнэлийг тодорхойлох гэж оролдоно.

¹⁴ Н.Я.Грот “Философия, как ветвь искусства”- Философия и ее общие задачи. СПб. 1904 (Хрестоматия по философии. М.,1998, С. 53,54)

¹⁵ Н.Я.Грот “Философия, как ветвь искусства”- Философия и ее общие задачи. СПб. 1904 (Хрестоматия по философии. М.,1998, С. 53,54)

¹⁶ Б.Батчулуун. Философи гэж юу вэ?. УБ., 2004, 17-18 дахь талаас үзнэ үү

Үзэгдлийн өрнөл хэмнэл, шинж байдлаас уг зүйлийн үр дагавар, ерөнхий хандлага төлөв байдал тодорч, түүнээс улбаалан уг үзэгдэл, үйл явдлын байгаль, нийгэмд үзүүлэх нөлөөлөл түүний эерэг, сөрөг талын онцлогийг тодруулах боломж гарч ирдэг. Ингэж хүн аливаа үзэгдэл, үйл явцын дотоод шалтгаан өрнөл, шинж хандлага, нөлөөллийн үр дагаварыг танин мэддэг байна. Ингэхдээ уг үзэгдэл үйл явцыг байнгын өөрчлөлт хөгжил, өрнөл дунд нь авч үзэх нь туйлын чухал байдаг. Хүний зөв сэтгэх буюу философидох нь ямар нэг хоёрдмол санаагүй, зөрчилгүй, хангалттай үндэслэгдсэн, нотолгоо үндэслэл нь ноттой баримт мэдээлэлд суурилсан, гаргалгаа дүгнэлт тодорхой цэгцтэй ойлгомжтой байх логикийн үндсэн хууль зарчимд тулгуурладаг. Ийм чадвар, мэдрэмж, эв дүйг хүнд философи түүний ерөнхий арга зарчим өгч байдаг. Түүнчлэн философийн чадвар гэдэг бол өөртөө байгаа янз бүрийн үзэл санааг нэгтгэж холбохоос гадна ялган салгах чадвар юм. Ийнхүү улс төрийн үзэгдлийн мөн чанарыг ойлгож мэдэхэд философи тусалдаг төдийгүй ингэж танин мэдэх үйл явцад ерөнхий баримжаа чиглэл нь болж өгч байдгаараа философи хүнд туйлын ач тус хүргэдэг байна.

Философи нь бүтээлч шүүмжлэлт сэтгэлгээ болдог. Философийг амьдралаас тасархай хоосон номчирхосон зүйл гэж үзэх нь байдаг. Тэгвэл философи угтаа тийм биш. Философийг хүмүүс тогтсон нэг хэвийн асуудлыг тойрч авч үздэг төдийгүй түүнийхээ орчил хязгаараас гарч чаддаггүй тогтонги зүйл гэж шүүмжилдэг. Тухайлбал улс төрийн философи гэхэд нийгмийг улс төрийн талаас нь явал шударга зүй зохистойгоор бүтээж, зохион байгуулах вэ? гэдэг асуудлыг ямагт тавьж тэгэж өөрчлөх зам мөрийг эрж олоход тусалдаг. Тэгвэл энэ асуудал нь хүн төрөлхтөнийн оршихуйн бүх цаг үед тавигдаж ирсэн “мөнхийн” асуудал юм. Тийм болохоор энэ асуудлыг зарим хүмүүс нэг ёсондоо хуучин асуудал гэх нь байдаг. Тэгвэл улс төрийн философийн судлагдахуун түүний хүрээнд тавигддаг асуудал бүр нь хүн төрөлхтөнийн оршихуйн бүх цаг үед тавигдаж ирсэн хуучин, тогтонги нэг асуулт байж болно. Тэгэхдээ энэ нь хүн төрөлхтөний оршихуйн бүх цаг үед цоо шинэ шинж агуулгаар шинэ өнгө аястайгаар бүр тулгамдсан зайлшгүй шийдвэрлэж хариу өгвөл зохих асуудал болон ямагт тавигдаж ирсэн нь үнэхээр гайхам юм. Ингэхлээр философи нь хуучин асуудалд хандах шинэ хандлага, үзэл бодлыг илэрхийлэх шинэ арга зам, улмаар философийн өөрийнх нь зорилго, үүргийн тухай шинэ хандлагыг байнга дэвшүүлдэг.

Философи нь тогтсон үзэл урсгалыг судлан шинжилдэг ч түүнээс ямагт тухайн цаг үед таарч нийцсэн хамгийн чухал санаа ойголт, үндэслэл, гаргалгааг нийгэмд гарган өгч, хүний шинэ үзэл бодлыг төлөвшүүлж байдаг. Хүнээс байнга юм асууж, шалгаж, шинийг мэдэхийг эрмэлздэг, өөрийгөө боловсруулахыг хичээж, өөрийнхөө бодол санааг хянаж шалгаж байдаг хүмүүсийн хувьд философи нь шүүмжлэлт чадвараа хөгжүүлэх, шинэ зүйлд татагдах байнгын эх үндэс болдог.

Философи нь бүтээлч төдийгүй *шүүмжлэлт сэтгэлгээ* мөн. Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь бүхнийг утга учиргүй үгүйсгэх хэлбэр бус, харин аливаад үндэстэй эргэлзэж, хуучныг шинэчлэн өөрчлөх, бурууг зөвөөр засах, зохисгүйг зохистой болгох ухаан юм. Энэ нь аливаа юмс үзэгдлийг дотоод үндэс, учир шалтгааны талаас нь хандан үнэлж, түүнийг бүхэлд нь бодитой, зүй зохистой ухааран бясалгах хэлбэр юм. Ийм шүүмжлэлт сэтгэлгээний хэлбэр нь философи болоод зогсохгүй тэрхүү шүүмжлэлт арга ухаан, чадварт хүнийг сургах хэрэгсэл нь мөн философи болдог байна.

Философи нь бүхэлдээ оюуны соёл мөн. Философичид философийг *оюуны соёл* хэмээдэг нь оргүй зүйл биш. Учир нь философийг эзэмших, түүнийг хэрэглэх, түүгээр философидоно гэдэг нь хүнээс соёлын өндөр түвшин, чадварыг шаардах төдийгүй энэ нь өөрөө бас соёл болдог. Тэгвэл соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? гэж хүмүүс байнга асуудаг. Хүний соёл нь гадаад өнгө үзэмжээр тодорхойлогдох төдий зүйл биш юм. Харин энэ нь хүний дотоод мөн чанар, ухамсар сэтгэлгээтэй илүүтэй холбогддог. Энэ агуулгаараа соёлтой хүн гэдэг нь зөв үг хэлтэй, зөв сэтгэлгээ, сэтгэх арга барилтай, зөв үйл хөдлөлтэй байх явдал юм. Ингэхлээр хүний соёлын үндэс, эхлэх цэг нь үг хэл, сэтгэх хэв шинж, арга барил болдог байх нь. Тэгвэл хүний тэрхүү зөв үг хэл, сэтгэлгээ, сэтгэх арга барилын үндэс нь *философи* болж байдаг.

Өндөр боловсролтой гэдэг ч аливаад нухацтай хандаж чаддаггүй, зөв цэгцтэй сэтгэж сураагүй, хүнд өөрийнхөө санааг зөвөөр ойлгуулж чаддаггүй хүнийг соёлтой хүн гэхэд хэцүү. Тэгвэл зөв сэтгэх арга барил, чадвар, дадал, эв дүйг философи хүнд өгдөг. Философийг зөвхөн мэдэх нь гол биш, харин философийг амьдрал ахуйдаа хэрэглэж сурах нэг ёсондоо философидож сурах нь хамгийн чухал юм. Хүний амьдралын зайлшгүй хэрэгцээ нь философидох явдал мөн. Хүн бүр албан ёсны философич биш юм гэхэд сайтар философидож сурах, философидох арга барилыг эзэмших хэрэгтэй болдог. Хүн сайтар философидож сурна гэдэг нь тухайн хүний оюуны соёлын маш чухал илэрхийлэл болдог. Хүний оюуны соёл нь дээр онцолсноор сэтгэх хэв шинж, арга барилаар нь дамжин мэдрэгдэж байдаг. Зөв сэтгэлгээтэй, арга барилтай байна гэдэг нь аливаад буйр суурьтай хандаж, юмны цаад учир зүй, үндэс шалтгааныг нь барьж сэтгэх, юмны эв дүй, зүй зохисыг олж харж, шийдэх чадвартай байна гэсэн үг. Зөв сайхан сэтгэж ярьдаг хүн зөв философидож байгаагийн илэрхийлэл болдог төдийгүй оюуны өндөр соёлтойн шинж яах аргагүй мөн.

Философи нь хувь хүмүүсийн хэрэглэж байгаа үг хэлнээс цааш гарч, тэдгээрийн үндсэн утга санааг нээн, үүнээс уламжлан нухацтай эрэгцүүлэл шаардсан ертөнцийн утга чанарыг хүнд танин мэдүүлэхэд туслаад зогсохгүй хүнийг хүн байх ухаанд сургаж, хүнийг аливаад бодитой хандах, зөв сайхан сэтгэх чадварыг эзэмшихэд тусалдаг. Ингэхлээр зөв философидоно гэдэг нь зөв сайхан сэтгэж байна гэсэн үг. Зөв сайхан сэтгэж байна гэдэг нь бүх зүйлд зүй зохисыг нь олж чадаж байна гэсэн үг. Бүх зүйлд зүй зохисыг нь олж чадаж байна гэдэг нь тэр хүн оюуны өндөр соёлтой байна гэсэн үг юм. Харин философи үгүй бол нийгэм оюун санааны үндэснээсээ салж, үнэт зүйлсээ тогтоон, өөрийгөө ойлгох талаар бүр эхнээсээ эхлэх хэрэгтэй болно. Нийгмийн түүхэн болон логик ирээдүйг философиор дамжуулан олж хардаг. Философи судалснаараа та Дорно, Өрнөдийн соёл дахь шилдэг сэтгэгчдийн хуримтлуулсан мэдлэгийг мэдэж, тэрхүү мэдлэг, давуу тал дээрээ тулгуурлан асуудлаа шийдэж байх болно.¹⁷ Ингэж хүн, философи, оюуны соёл гурав бие биенээ нөхөн сэлбэж, өөр хоорондоо сүлжилдэн цогцлож байдаг байна. Философийг судлахын учир зүй нь чухам энд л оршиж байгаа юм. Улс төрийн философийг судлахын ашиг тус, учир холбогдол ч бас энэ юм. Учир нь улс төрийн философи бол угтаа мөн л философи мөн билээ.

Хувь хүний амьдралтай холбоотой ёс зүйн маш олон асуудлаас бид ямар нийгэмд амьдрахыг хүсэж байдаг, засаглал ямар байх ёстой, иргэдийн эрх, үүрэг, хариуцлага гэх мэт асуудлууд уруу орох нь зүй ёсны хэрэг билээ. Философийн сүүлчийн гол салбар болох улс төрийн философи нь эдгээр асуудлыг авч үздэг бөгөөд улс төрийн философичид Платогийн БНУ-аас эхлээд К.Марксын Коммунист намын тунхаг хүртлэх бүх бүтээлдээ нийгмийг хэрхэн зохион байгуулах вэ? гэдэг асуудлыг авч үзсэн байдаг.¹⁸ Түүнчлэн нийгмийг хэрхэн шударга ёсны зарчмаар зохион байгуулах вэ?, тэгш ёс ба шударга хуваарилалт, нийгмийн шударга ёс гэж юу вэ? хүний эрх, эрх чөлөөний утга чанар, түүнийг хэрэгжүүлэх боломжууд, эрх чөлөө, эрх мэдэл, эрх мэдэл ба хариуцлагын харьцаа зохицол, улс төрийн институт, засаглал, засаглалын хэлбэр тэдгээрийн зохистой зүй ёсны байдал гэх зэрэг философийн хариу нэхсэн олон асуудал нийгмийн улс төрийн амьдралын өрнөлтийн явцад тавигддаг. Тэр бүхэн хүмүүсийн улс төрийн танин мэдэхүйн суурь асуудлууд болж бүхний сонирхол, хэрэгцээг эзэмдэж байдаг. Чухам энэ бүх асуултанд хариу өгөхөд тус болохуйц бодомж, эрэгцүүлийн суурь үндсийг улс төрийн философи хүмүүст өгдөг. Энэ агуулгаараа улс төрийн философи нь өнөөгийн соёлт хүмүүсийн судлаж, эзэмшвэл зохих мэдлэгийн чухал салбар болдог. Философичдийн зарим хэсэг нь философийг заалгадгүй, бас философид суралцдаггүй хэмээдэг. Гэвч энэ нь харьцангуй ойлголт бөгөөд “философид суралцана” гэдэг нь үнэндээ аливааг философидох арга барицыг эзэмшинэ гэсэн үг юм. Иймд улс төрийн философид суралцахын тулд улс төрийг философидон эрэгцүүлэх бясалгах арга чадавартыг эзэмшинэ гэсэн үг болох нь тодорхой байна. Энэ бүхнээс үзвэл хүн улс төрийн философийг үндэстэй эрэгцүүлж, буйртай ухааран бясалгаж, өөрийгөө дээд зэргээр хянаж, бүтээлч шүүмжлэлтэйгээр сэтгэх чадварт суралцан, оюуны өндөр соёлтой байхын тулд түүнийг эзэмшиж, түүгээр улс төрийг философидохыг эрмэлзэж байдаг байна. Хэдийгээр улс төрийн философи нь Б.Расселийн хэлсэнчлэн “... бидний хүсэн хүлээж буй олон асуултад хариулт өгч чадахгүй хэдий ч наад зах нь ертөнцөд хандах бидний сонирхолыг хүчтэй болгогч асуулт тавих замаар хамгийн жирийн юмсыг үзэх энгийн үзэл бодлын хил хязгаараас халин гарсан гайхамшгийг бидэнд үзүүлж чаддаг байна.”¹⁹

Abstract: By the way, philpsophy works, it is considered to be a political philosophy as well. Therefore, what is political philosophy, really?

НОМ ЗҮЙ:

1. Б.Даш-Ёндон. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. III боть, УБ., 2011
2. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи: асуудал, аргачлал, ашиг тус. УБ., 2013
3. Бэртран Рассел. Өрнийн мэргэн ухаан. УБ., 2015
4. Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохуй. УБ., 2007
5. Бэртран Рассел. Философийн асуудлууд. УБ., 2014
6. Б.Батчулуун. Философи гэж юу вэ?. УБ., 2000
7. Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн философи: удиртгал. УБ., 2015
8. И.Кант. Трактаты и письма. М., 1980
9. Б.С. Соловьев. “Исторические дела философии”. Вопросы философии. 1988. №8.
10. Лео Штраус. Введение в политическую философию. М., 2000
11. Мэл Томпсон. Философи. УБ., 2012
12. Хрестоматия по философии. М., 1998
13. “Философи: агуу сэтгэмжүүдийг энгийнээр тайлбарлах нь” УБ., 2015

¹⁷ Мэл Томпсон. Философи. УБ., 2012, Удиртгал XXV тал

¹⁸ “Философи: агуу сэтгэмжүүдийг энгийнээр тайлбарлах нь”. 15 дахь тал

¹⁹ Б.Рассел. Философийн асуудлууд. 14 дахь тал.